

ДУРТГАЛ, ТЭМДЭГЛЭЛ

КЮСЮ АРАЛД ЗОРЧСОН МИНЬ

Японы нийслэл Токио хотноо 160 гаруй мянган гадаадынхан амьдарч байгаа нь тус улсын нийт хүн амын 0,13 %-тай тэнцэж байна. Дэлхийн 105 орны элчин сайдын яам, 21 орны консулын газар, олон улсын 12 байгууллага, гадаадын хөрөнгө оролцсон 328 пүүс, гадаадын банкны 297 салбар, хэвлэлийн 79 агентлаг Токиод байдаг. Зөвхөн энэ баримтаас л үзэхэд Япон улс нь орчин үеийн олон улсын харилцааны томоохон төвийн нэг болжээ. Гадаад орнуудтай харилцаа холбоогоо өргөжүүлэхийн тулд гадаадынхныг урьж яриа хийлгэх, соёл, спортын олон төрлийн арга хэмжээ хамтран зохиох, япончуудын уламжлал, зан заншлын талаар яриа хичээл явуулах төвүүд энд тэндгүй ажиллаж байна. Мөн Японд хувийн зардлаар, түр буюу удаан хугацаагаар ажиллаж, сурахаар ирсэн гадаадын хүмүүсийг байр сууцаар хангах, тэдэнд ажил төрөл олгох, шаардлагатай үед нь тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлж, зөвлөлгөө өгөх олон тооны газар байдаг. Японд хоёр жил шахам сурч, амьдрахдаа би ч нутаг ус, гэр орноо санах, ганцаардах, тулгамдах явдал гарч л байлаа. Гадаад оюутны байранд амьдардаг байсан тул эхний үед сургууль, байр хоёрын хооронд явсаар байтал өдөр өнгөрдөг байв. Япон хүмүүстэй ярьж хөөрөх, дотно харилцах, японы нийгмийн амьдралын нарийн ширийн зүйлийг ойлгож мэдэх боломж тэр бүр олддоггүй байлаа. Иймээс ч япончуудын амьдралын гүнд орон, тэдний өдөр тутмын амьдралыг мэдэх юмсан гэж боддог байв. Мөрөөдөл маань биелж «Караимо коорюу» («караимо төмсний нэг төрөл, «Коорюу-харилцаа холбоо») хөтөлбөрт оролцохоор Японы өмнө зүгийн Кюсю аралд хүрч очлоо. Энэ нь Токио, Осака зэрэг том хотуудад суралцаж байгаа гадаадын оюутнуудыг (1982 оноос) японы хөдөө нутгийн аж амьдралтай танилцуулах зорилготой арга хэмжээ юм. Энэ жил 21 орны 95 оюутан дээрх хөтөлбөрт оролцлоо.

Би Өмнөд Солонгос, Ирланд, Малайз, Шри Ланкийн дөрвөн оюутны хамт Кюсю арлын Миязаки мужийн Ямада-чэ (чэ нь засаг захиргааны нэгж)-д 20-иод хоног амьдарсан. Ямадад 8897 хүн оршин суудаг. Хүн ам нь гол төлөв газар тариаланг эрхэлж ирсэн боловч сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ буурч, цагаан будааны талбай багассан зэрэг бэрхшээлтэй асуудлыг даван туулахын тулд мал аж ахуй (гахай, шувуу, сүүний болон махны чиглэлийн үхэр)-г голчлон эрхлэх боллоо. Мөн хүн амыг суурьшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэхийн тулд нэхмэл, хуванцар, эдлэл, төмөрлөгийн зэрэг 13 үйлдвэр байгуулжээ.

Ямадагийн оршин суугчдын эрхэмлэн заавал биелүүлэх журамд дараах зүйлийг дурьдсан байсан нь миний анхаарлыг ихэд татсан юм. Үүнд:

- Үзэсгэлэнт байгалиа хайрлан хамгаалж, саруул сайхан орчныг бий болгох,

Ахмадуудын туршлагыг эрхэмлэн, бүтээлч сэтгэхүйгээ хөгжүүлж, ажил үйлсээ чин сэтгэлээсээ, хичээнгүй шаргуу хийх.

- Зоримог сэтгэлтэй, эрүүл чийрэг биетэй, хайр сэтгэлийг дээдэлдэг, аз жаргалтай гэр бүлийг бүрдүүлэх,

- Ес журмыг хүндэтгэн, харилцан туслалцан сайн сайхан нийгмийг байгуулах,

Төрөлх нутгаа баян тансаг, амгалан тайван байлгахын төлөө бүх хүчээ зориулах ёстой.

Миний очсон айл зургаагаас арван насны 3 хүүхэд, 84 настай өвгөн буурал, 40 эргэм насны эхнэр, нөхөр хоёр амьдардаг байв. «Азийнхан хоорондоо андуурмаар адил төстэй юм. Бид урьд нь гадаадын хүн гэвэл цайвар царайтай, цэнхэр нүдтэй, шар үстэй л байх юм шиг боддог байсан» гэж тэд ярьж байв. Миний амьдарч байсан айлын эзэгтэй «Гадаадын хүн ирнэ гэж сонсоод би их мэгдэж сандарсан. Англи хэл ч мэдэхгүй учир ойлголцохгүй байх, унтах ор ч байхгүй (Япончууд газарт унтдаг), боловсон жорлон ч байхгүй яана даа гэж санаа их зовж байсан шүү. Манай хөрш айлын авгай «гадаадын хүн ирвэл үнээний маань сүү гарахгүй, тахиа өндөглөхгүй болчих вий гэж айж байсан» хэмээн хүүрнэж билээ. Японы хөдөө нутгийн хүмүүс монгол чуудтай их төстэй байсанд би гайхсанаа нуух юун.

Тэнд байхад орой болгон хавь ойрын хүмүүс цугларч, надаас монголын тухай элдвийг сонирхон асууж хууч хөөрдөг байлаа. Тэдний дунд монголын талаар огтхон ч төсөөлөлгүй хүн байхад, тодорхой мэдлэгтэй хүн ч байв. «Чингис хааны өлгий нутгаас ирсэн бүсгүй» гэж намайг ихэд хүндэтгэж байсан. Манай орны тухай сүүлийн үед сонин хэвлэлд өргөн нийтлэх болсон учир Монголд явагдаж байгаа өөрчлөн байгуулалтыг японы хөдөө нутагт ч их сонирхож байгааг би нүдээрээ үзэж, чихээрээ сонслоо. «Ёмиури» сонины 1990 оны I-р сарын 1-ний дугаарт танай орны тухай өнгөт зурагтай арваад хуудас материал гарсан нь Япон, Монгол хоёр орны харилцаа улам өргөжихийн бэлэг тэмдэг юм» гэж Ямадагийнхан баяр хөөр болон өгүүлж байсан нь сэтгэлд таатай байлаа.

Манай орон мал аж ахуй эрхэлдэг гэж ярихад: «бид тэнд очиж, машин техник, мэдлэг, туршлагаа солилцох юмсан. Монголын залуучуудыг урьж, тэдэнд ихийг зааж өгөх юмсан» гэж ярьж байв. Японы хөдөө нутаг нь дэлхийн II дайны өмнө зөвхөн анжис, хадуур зэрэг багаж зэвсэг хэрэглэж байсан бол одоо дээд зэргээр автоматжилагдсан сан механикжсан бөгөөд япончуудын хэрэглэж байгаа хөдөө аж ахуйн техникийг тоолж барамгүй, «Автоматжуулалт хөгжсөнөөр хамтын хөдөлмөр, харилцан туслалцах явдал, хүнлэг харьцаа үгүй болсон юм. Автоматжуулалт нь хүнийг материаллаг талаас нь баян чинээлэг болгосон боловч, байгалийг эвдэн сүйтгэж, хүмүүсийн хоорондын харьцааг хөндий хүйтэн болгосон юм» гэж Фужимори Тэцуя гэдэг тариачин ярьж байв. Япончуудын энэ алдааг бусад орон битгий давтаасай, байгалиа, хүнлэг харьцаагаа мөнхөд хадгалаасай гэж монгол хүмүүст надаар дамжуулан захисныг та нарын сонорт хүргэе.

Зүүн өмнөд Азийн хөдөө тосгоноос Ямадад залуучуудыг урьж ажиллуулан, Японы хөдөө аж ахуйн техник, ажлын арга барилыг тэдэнд зааж эзэмшүүлэх хөдөлгөөн өрнөж байгаа ажээ. Намайг очиход Филиппинээс дөрвөн залуу ирж ажиллаж байв. «Япончууд үнэхээр эцэж цуцалгүй ажиллах юм. Бид дасаагүй учир их ядарч байна. Бид нутагтаа маш ядуу амьдралтай. Эндээс их юм сурч очоод нутгийнхаа хүмүүст зааж өгнө. Танай орноос бид нарын нэгэн адил залуучууд ирж ийнхүү ажиллавал их юм сурах байх даа» гэж тэд ярьж байв. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хөдөө тосгоны амьдралыг сайжруулах зорилгоор хэрэглэхгүй болсон техникээ Филиппины хөдөө тосгонд явуулдаг юм байна. Гэтэл тэр техникийг «уужуу тааваараа ажилладаг манайханд нүргээнтэй, хэт их хурдтай энэ техник чинь таарахгүй» гээд зарим нь түүнийг ашигладаггүй гэж япончууд ярьж байв. Үнэндээ ч Японыг хэмжих хэмжүүр нь Азийн буурай орнуудынхтай адил байх аргагүй юм гэж би бодлоо. «Эдийн засгийн хөгжил бүхий

том гүрний цэцэрлэгт ургасан цэцгийн зөвхөн үрийг нь аваачиж,, хөгжиж байгаа орнуудад тарих юм бол мэдээж хатаад дуусна» гэж миний амьдарч байсан айлын нөхөр нь ярьж байлаа.

Японоос Азийн орнуудад үзүүлж буй тусламжийн талаар сонин хэвлэлд их бичиж байна. Сүүлийн 10 жилийн дотор Японы засгийн газраас Азийн орнуудад үзүүлсэн тусламж нь дөрөв дахин өссөн байна. Энэ нь тооны хувьд гайхамшигтай өсөлт боловч чанарын хувьд чухам ямар байгаа, тэдгээр орны эрх ашигт нийцэж байна уу, үгүй юу? гэдэг асуулт тулгарч байна. Японы тусламжаар Азийн орнуудад дээд зэргийн зочид буудал, орчин үеийн тоног төхөөрөмж бүхий эмнэлгийн төв барьсан хэдий ч ажиллах боловсон хүчин байхгүйгээс ашиглахгүй байна гэж японы сонинд их бичих боллоо. Иймд японы тусламжийг авснаар манай улс чухам ямар ашиг олох, уг тусламж нь байгалийн унаган төрхийг хэвээр нь хадгалж чадах эсэхийг нарийн харгалзах нь зүйтэй юм шиг санагдлаа.

Ямадад байх хугацаандаа нэгэн дунд сургуульд очиж үзэв. Эрүүл чийрэг бие бялдартай, өргөн мэдлэгтэй хүүхэд багачуудыг өсгөн хүмүүжүүлэхийн тулд их зүйл хийдэг юм байна. Жишээ нь ойр хавийн айлууд амралтын өдрүүдэд цугларч, ууланд гарч хүүхдүүдтэйгээ тоглон наадан өнгөрөөдөг ажээ. Миний очих үеэр сургуулийн хичээлийн жил дуусч байсан. Бага сургуулиас дунд сургуульд шилжиж байгаа хүүхдийг урамшуулан шагнаж, эхчүүд нь өөрийн гараар хийсэн хоолоороо дайлж цайлан, эцгүүд нь биеийн тамирын тоглоом наадам зохиож байв.

Ямадагийн цэцэрлэгийн ахлах ангийн төгсөлтийн өдөрлөгт ч оролцож үзлээ. Цэцэрлэгээс сургуульд дэвшиж байгаа хүүхдүүдэд диплом гардуулан, тэдний зан ааш, авьяас билэг, сул талыг багш, хүүхдүүд хошин, сонирхолтой хэлбэрээр танилцуулж, бага ангийнхан концерт тоглож байв. Өдөрлөгийг эхнээс нь дуустал хүүхдүүд өөрсдөө удирдаж явуулсан нь их сонин санагдсан. Япон хүүхдүүд маш нүүрэмгий, санаж бодож байгаа зүйлээ ойлгомжтой, цэгцтэй хэлж ярьдаг, хүмүүстэй эвсэг найртай, биеэ цэвэр цэмцгэр авч явдгийн гол нууц нь хүүхэд, эхийн харьцаа маш дотно, сургалт хүмүүжлийн систем нь боловсронгуйд л байдаг юм байна даа гэж надад бодогдсон юм.

Ямадад байгаа жижиглэн худалдаалах 128 цэг, хоолны 14 газар нь жилд 3,5 миллиард иений (23 сая ам. доллартай тэнцэнэ) бараа гүйлгээ хийдэг гэнэ. Хоолны газрыг өвөрмөц онцлогтойгоор засч чимэглэн, өөр хаана ч байхгүй, ховор сонин хоол хийдэг юм байна. Жишээ нь зөгийн авгалдайтай шөл хийх юм. Ер нь ногоо, жимс их иддэг гэнэ. Монголчуудын дундаж наслалт 64 гэж хэлэхэд маш гайхан: «ногоо сайн идвэл япончууд шиг урт наслана даа» гэж ярьцгааж байв. Дэлгүүрт хүний хэрэгцээт бүх юм байлаа. Үйлчилгээ нь хот суурин газраас дутахгүй боловсон шуурхай юм. Ер нь Японд хот, хөдөөгийн ялгаа арилжээ гэж би бодсон.

Айл бүр 2—3 авто машинтай, гэр ахуйн цахилгаан хэрэгслээр иж бүрэн хангагдсан нь эмэгтэйчүүдийн ажлыг хөнгөвчилөн, чөлөө зав гаргаж өгч байна. Иймээс эмэгтэйчүүд нь төрөл бүрийн дугуйланд (найрал дуу, азробик, уран зураг, гадаад хэл) явж, чөлөөт цагаа маш боловсон өнгөрөөдөг юм байна. Японы хөдөө нутгийн хүмүүс маш элэгсэг дотно, зочломтгой, ажилсаг, ууж наргиж ч чаддаг юм байна. Үндэсний, ялангуяа тухайн нутаг орныхоо дуу, бүжгийг хүн бүхэн сайн мэддэг нь надад их сургамжтай санагдсан юм.

Ер нь дэлхий дахины байдал, ялангуяа Азийн орнуудын талаар их сонирхож, тэдгээрт холбоо харилцаа тогтоох эрмэлзэл дүүрэн байгаа нь илт харагдаж байлаа. «Улс төрийн бодлого ямар ч байсан хамаагүй, хүнлэг харьцаа тогтоож, харилцан туслалцаж, хамтран хөгжье» гэж хөдөө нутгийнхан ярьж байв.

Азийн орнууд урьд нь Европын загвараар хөгжиж ирсэн. Гэвч энэ нь тэр болгон тэдгээрт таарахгүй тул Азийн загвараар л замнах нь зүйтэй. Ийм учраас дэлхийн эдийн засгийн хөгжилтэй орнуудын доторх азийн цорын ганц орон Японд бид их найдвар тавьж байна. Дэлхий гэдэг нэгэн гаригт хувь заяагаа холбон амьдарч байгаагийн хувьд харилцан бие биеэ ойлголцох нь юу юунаас чухал юм. Япон яагаад техникийн ийм өндөр дэвшилд хүрч чадав аа? Үүнийг мэдэхийн тулд тус орны соёл, түүх, япончуудын сэтгэлгээ, үзэл бодлыг нарийн судлах хэрэгтэй болов уу. Япон ч Азийн орнуудаас өөрийн мэдэхгүй чадахгүй, анзаарахгүй орхичихсон зүйлийг сурах явдал нь дэлхийн бусад орнуудтай харилцах харилцааг улам баяжуулан ойртуулж өгөх юм.

«Монгол бүсгүйтэй ийнхүү танилцсанаар бид урьд өмнө огтхон ч сонсож байгаагүй танай орны талаар ихийг мэдэж, гойд сонирхох боллоо. Монгол оронд заавал очиж үзнэ. Монгол нутагт дахин уулзъя» гэж Ямадагийнхан намайг үдэж билээ.

Японы түүх, соёл, байгаль, япон хүмүүсийн амьдрал байдал, уламжлал, зан заншилтай танилцаж, хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд маань Ямадад зочилсон 20 хоног надад ийнхүү хэзээ ч мартагдашгүй сайхан дуртгал болон сэтгэлд хоногшсон юм.

М. Нарантуяа